



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 47 (184)

(Тусгай дугаар)

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2000 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны арванхоёрдугаар сарын 14 №47 (184)  
(Тусгай дугаар)

## Гарчиг

506. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан  
нэмэлт, өөрчлөлт

829

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

2000 оны 12 дугаар  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### Нэгдүгээр зүйл

Монгол Улсын Үндсэн хуульд  
дараахь заалт нэмсүгэй:

**1/ Хорин хоёрдугаар зүйлийн 2  
дахь хэсэгт:**

"Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол  
Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох  
саналыг Улсын Их Хуралд өргөн  
мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор  
Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж  
чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл  
Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их  
Хурлыг тараах тухай шийдвэр гаргана."

**2/ Гучин есдүгээр зүйлийн 2 дахь  
хэсэгт:**

"Ерөнхий сайд уул асуудлыг  
Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор  
зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд  
өөрөө өргөн мэдүүлнэ."

### Хоёрдугаар зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин  
дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, хорин  
долдугаар зүйлийн 2, 6 дахь хэсэг, хорин  
есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, гучин  
гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь  
заалтыг дараахь байдлаар өөрчлөн  
найруулсугай:

**1/ Хорин дөрөвдүгээр зүйлийн 1  
дэх хэсэг:**

"1. Улсын Их Хурлын дарга, дэд  
даргыг Улсын Их Хурлын гишүүдийн  
дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр  
гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн  
сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн  
бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд  
даргыг сонгоно."

**2/ Хорин долдугаар зүйлийн 2 дахь  
хэсэг:**



"Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна."

хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй."

### 3/ Хорин долдугаар зүйлийн 6

дахь хэсэг:

"6. Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ."

### 4/ Хорин есдүгээр зүйлийн 1 дэх

хэсэг:

"1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад,

### 5/ Гучин гуравдугаар зүйлийн 1

дэх хэсгийн 2:

"2/ Улсын Их Хуралд олонхи суудал

авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;"

### Гуравдугаар зүйл

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ

2000 оны арван хоёрдугаар сарын 14 – ний өдрийн 16 цаг 35 минут буюу арван долдугаар жарны төмөр луу жилийн өвлийн тэргүүн улаагчин гахай сарын 18-ны хүчин төгсөхийн барилдлагаатай өлзийт сайн улаан морин өдрийн бичин цаг.

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 329487